



*The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia*

**Хэвлэлийн мэдээ**  
2019.05.08

**Холбоо барих**  
+976 9511 7771

## **Монгол Улс уул уурхайн мөчлөгийг сөрөх боломжийг бүрэн дүүрэн ашиглах хэрэгтэй**

**УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс** – Монгол дахь Америкийн Худалдааны Танхимын (АмЧам Монгол) тавдугаар сарын ээлжит Бизнес уулзалтаар “Монгол улсын санхүү эдийн засгийн зохистой тогтолцоо хөгжүүлэх бодлогын зөвлөмжүүд” сэдвээр панел хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уулзалт 2019 оны 5-р сарын 8-ний өдрийн Лхагва гарагт Шангри-Ла зочид буудалд боллоо. Уулзалтад АмЧам-ын гишүүн байгууллагууд, хувийн хэвшил, Монгол дахь гадаадын элчин сайдын яамд болон олон улсын байгууллагын төлөөлөл оролцов. Оролцогчид Монгол Улсад санхүү, эдийн засгийн зохистой тогтолцоо хөгжүүлэхэд шаардлагатай бодлого, эдийн засгийг төрөлжүүлэх бодлогын арга хэмжээний талаар саналаа танилцуулж хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчдын төлөөлөлтэй санал солилцож хэлэлцүүлэг хийлээ. Панелистууд эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоход хувийн хэвшлийн үүрэг оролцоо нэн чухал гэдгийг онцлон тэмдэглэлээ.

Дэлхийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгч Андрей Михнев эдийн засгийн хямралын дараа Монголд ядуурлын түвшин эрс нэмэгдсэн ба Дэлхийн Банкны зүгээс ядуурлыг бууруулах талаар тууштай ажиллаж байгаа гэв. Засгийн газрын тогтвортой бодлого үргэлжилбэл энэ жил дотоодын нийт бүтээгдэхүүн 7.2%-аар өсөж шинэ ажлын байр нэмэгдэж, ядуурал буурна гэж онцлон тэмдэглэв. Михнев үргэлжлүүлэн “Ойрын хугацааны эдийн засгийн эрсдэлийг тодорхойлж хэлэхэд 2020 оны сонгуультай холбоотой улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, БНХАУ болон АНУ хоёрын худалдааны маргаантай асуудал, авилга, цаг уурын өөрчлөлт” хэмээн өгүүлэв.

Олон Улсын Валютын Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Ниел Сакер ОУВС-тай хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилт 2020 онд дуусна гэдгийг цохон тэмдэглэв. Харин банк санхүүгийн салбарт Монголын банкууд эдийн засгийн хөгжилд илүү идэвхтэй оролцох хэрэгтэй бөгөөд ялангуяа финтек, цахим банкны салбар дахь асар их боломжийг ашиглах хэрэгтэй гэв. Ниел Сакерын санаа зовж буй асуудал бол бодлого, хуулийн тогтворгүй байдал гэж онцоллоо. “Сонгууль бүрийн дараа төрийн албан хаагчдыг өөрчилдөг нь бодлогын залгамж чанарын асуудалд маш сөрөг нөлөөтэй байдаг. Мөн тэрээр Монгол Улсад хөрөнгийн зах зээлийг улам эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай” гэв.

Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Монгол дахь суурин төлөөлөгч Руфат Алимарданов хэлэхдээ эдийн засгийн хөгжлийн бодлого тухайн орны онцлог нөхцөл байдлаас шалтгаална. Монголын хувьд эдийн засгийг төрөлжүүлэх нь өсөлтийг хангахаас илүүтэй тэнцвэртэй эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах юм. Эдийн засгийг төрөлжүүлэх нь ажлын байр бий болгож, институцын хөгжилд ач холбогдолтой байх болно. Гадаадын шууд хөрөнгө оруулалт Монголд зайлшгүй хэрэгтэй бөгөөд өнөөдөр Оюу Толгойгоос өөр салбарт гадаадын хөрөнгө оруулалт үнэндээ алга, тухайлбал, банкны салбарт хөрөнгө оруулагчид орж ирэхгүй байна. Мөн санхүүгийн тогтвортой байдлыг хангах нь нэн чухал байна гэж онцлон тэмдэглэлээ.

**АмЧамын Монголын тухай**

**[www.amcham.mn](http://www.amcham.mn)**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.